

Бугат сумын Эрүүл мэндийн төвд хяналт шалгалт
хийсэн тухай

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2017 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө, Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын баталсан 2017 оны 10 сарын 06-ны өдрийн 1/19 дүгээр удирдамжийн дагуу Бугат сумын Эрүүл мэндийн төвийн 2015, 2016 оны санхүү аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Эрүүл мэндийн тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд оршино.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ж.Оюун 2017 оны 10 сарын 09-ний өдрөөс хуанлын 8 хоногт багтаан төлөвлөгөөт шалгалтыг хийв.

ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Бугат сумын Эрүүл мэндийн төвийн 2015, 2016 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, олговор, албан томилолтын бодолт, олголт, хүнсний бүтээгдэхүүн, эм, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, үлдэгдлийн байдал, нэмэлт орлого түүний бүрдүүлэлт, зарцуулалт, шатахууны олголт, зарцуулалт, хэтрэлт хэмнэлт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, санхүү, төсвийн ил тод байдлын хэрэгжилт, “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг бүрэн хамруулав.

ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ
ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Бугат сумын 3-р багт байрлах 9012966 регистрийн дугаартай Эрүүл мэндийн төв нь нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг иргэдэд жигд хүртээмжтэй хүргэж үйлчлэх зорилготой.

Сумын хүн ам 2015 онд 2234, 2016 онд 2236 байгаа ба тус төв нь стандартаар 2-р зэрэглэлд хамаардаг.

Булган аймгийн Засаг даргын 2014 оны 11 сарын 27-ны өдрийн А/463 дугаар захирамжийн хавсралтаар Эрүүл мэндийн төвийн бүтэц, орон тооны дээд хязгаарыг нийт 18 ажиллагсадтайгаар буюу их эмч 2, сувилагч 4, багийн эмч 2, үйлчлэгч 2, галч 2, сургалтын арга зүйч ахлах сувилагч, эх баригч, статистикч, нягтлан бодогч, тогооч, жолооч тус бүр 1 байхаар /2015 онд/ батлагдсанаас дарга 1, эмчлэгч эмч 0.5, арга зүйч, сувилагч 4, үйлчлэгч 4, багийн бага эмч 2, эх баригч бага эмч, дүн бүртгэгч бага эмч, тогооч, жолооч, галч 4, дархлаажуулалтын сувилагч, архив бичиг хэргийн ажилтан, ахлах сувилагч, нярав нар хавсарч буюу 0.5 гэсэн орон тоотой ажилласан байна.

2016 онд сумын Эрүүл мэндийн төвийн даргын 06 сарын 24-ний өдрийн Б/16 “Орон тоо батлах тухай” тушаалаар нийт 18 ажиллагсадтайгаар буюу их эмч, эх баригч эмч, дүн бүртгэгч бага эмч, уламжлалтын бага эмч, ахлах сувилагч, нийгмийн эрүүл мэндийн сувилагч, тогооч, жолооч тус бүр 1, сувилагч 4, багийн эмч 2, үйлчлэгч 4 орон тоотойгоор баталсанаас дарга 1, их эмч 1 (эмчлэгч эмч, даргын үүрэг гүйцэтгэгчийг 07 сар хүртэл 0.5-аар), эх баригч бага эмч, дүн бүртгэгч бага эмч, уламжлалтын бага эмч, ахлах сувилагч, нийгмийн эрүүл мэндийн сувилагч, тогооч, жолооч тус бүр 1, сувилагч 4, багийн эмч 2, үйлчлэгч 4, слесарь, 2016 оны 05 сар хүртэл 4 галч, дархлаажуулалтын сувилагч (10 сар хүртэл), архив бичиг хэргийн ажилтан, нярав нар хавсарч буюу 0.5 гэсэн орон тоотойгоор ажилласан байна.

Тус төвийн санхүүгийн үйл ажиллагааны 1-р гарын үсгийг 2015 оны 01 сарын 01-ээс 10 сарын 30-ны өдөр, 2015 оны 12 сарын 04-ээс 2016 оны 03 сарын 09-ний өдрийг хүртэл А.Хандаш, 2015 оны 11 сарын 02-оос 12 сарын 04-ний өдөр, 2016 оны 03 сарын 10-аас 07 сарын 8-ны өдрийг хүртэл эх баригч бага эмч Г.Туул, 2016 оны 07 сарын 18-оос 12 сарын 31-ний өдрийг дуустал Д.Батжаргал, 2-р гарын үсгийг 2015 оны 01 сарын 01-нээс 2015 оны 12 сарын 04-ний өдрийг хүртэл Б.Дагийсүрэн, 2015 оны 12 сарын 07-оос 2016 оны 12 сарын 31-ний өдрийг дуустал С.Нямсүрэн нар тус тус зурсан ба төрийн санд бүртгэлийн 040220001 тоот, нэмэлт санхүүжилтийн 040220401 тоот данстайгаар орлого, зарлагын гүйлгээг хийж, хөрөнгө мөнгийг захиран зарцуулж иржээ.

Нягтлан бодох бүртгэл болон няравын тайланг санхүүгийн тооцоолох “СТS” программаар бүртгэж хөтөлсөн байна.

ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Бугат сумын Эрүүл мэндийн төвийн 2015, 2016 оны санхүүгийн тайлан түүвэрт хамрагдсан тул аймгийн Аудитын газраас дүгнэлт өгөгдөөгүй байна.

Шалгалтанд хамрагдсан онуудын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд бусад байгууллагаас шалгалт хийгдээгүй байна.

ЗУРГАА. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Бугат сумын Эрүүл мэндийн төвийн 2015-2016 оны касс харилцах, хүнс, эм, бараа материалын баримт, цалингийн карт, үдэж архивлагдаагүй байгууллагын даргын тушаал, санхүүгийн тайлан, сумын эрүүл мэндийн төвийн даргын 2016 оны 07 сарын 10-ний өдрийн А/15 дугаар тушаалаар баталсан хөдөлмөрийн дотоод журам, 2016 оны 11, 12 сарын үдэгдэж архивлагдаагүй эргэлтийн эмийн сангийн болон тендерийн эмийн барист зэрэг баримт материалуудад тулгуурлан нягтлан бодогч Б.Дагийсүрэн, С.Нямсүрэн, П.Мөнхтогтоо, жолооч С.Наянтай нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

6.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар:

2015 онд төсвөөс 236046.1 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж батлагдсаны дагуу авсан, үндсэн үйл ажиллагааны орлогыг 142.8 мянган төгрөгөөр

төлөвлөж, 71.4 мянган төгрөгийг оруулж, нийгмийн даатгалын сангаас жирэмсэн амаржсаны тэтгэмжид 4991.8 мянган төгрөг орж бүгд 241109.3 мянган төгрөгийн эх үүсвэртэй ажилласан байна.

Төсөвт зардлыг 236188.9 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр ажиллагсадтай холбоотой зардалд 179508.6 мянган төгрөг, тогтмол зардалд 10218.6 мянган төгрөг, нормативт зардалд 13662.5 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 8126.6 мянган төгрөг, урсгал засварын зардалд 1340.0 мянган төгрөг, албан томилолтын зардалд 658.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 257.6 мянган төгрөг, ном, архивын программ 337.0 мянган төгрөг авсан, нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн төсөл хөтөлбөрийн зардалд 2871.0 мянган төгрөг, материалын зардалд 56.9 мянган төгрөг нийт 217036.8 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 19080.7 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

2016 онд төсвөөс 242216.6 мянган төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөж батлагдсаны дагуу, нэмэлт санхүүжилтийн дансаар 3692.4 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоор 40.0 мянган төгрөг (сувилагч Цэрэндэжидийн 9.10 сарын түрээсийн төлбөр), “Эрүүл мэндийн довтолгоо” хөтөлбөрийн татан төвлөрүүлсэн үлдэгдэл 500.0 мянган төгрөг, нийгмийн даатгалын сангаас жирэмсэн амаржсаны тэтгэмжид 2623.8 мянган төгрөг бүгд 249072.8 мянган төгрөгийн эх үүсвэртэй ажилласан байна.

Төсөвт зардлыг 242216.6 мянган төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр ажиллагсадтай холбоотой зардалд 175980.7 мянган төгрөг, тогтмол зардалд 14574.0 мянган төгрөг, нормативт зардалд 20489.8 мянган төгрөг, хангамж бараа материалын зардалд 12781.5 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардалд 1389.9 мянган төгрөг, урсгал засварын зардалд 4623.6 мянган төгрөг, албан томилолтын зардалд 791.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ буюу галч нарын цалинд 7622.9 мянган төгрөг, магадлан итгэмжлэлийн үйлчилгээний төлбөрт 450.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 254.5 мянган төгрөг, төсөл хөтөлбөрийн зардалд 3827.7 мянган төгрөг, хөрөнгө бэлтгэх зардалд 1481.9 мянган төгрөг бүгд 244268.2 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 2083.8 мянган төгрөгийг татан төвлөрүүлж, арилжааны банкны үлдэгдэл 97.0 мянган төгрөг байна.

Тус сумын Эрүүл мэндийн төвийн магадлан имтгэмжлэлийн хугацаа 2016 оны 10 сард дууссан учраас хугацааг сунгуулахаар магадлан имтгэмжлэлийн үйлчилгээний төлбөрт 450.0 мянган төгрөг төлсөн байна.

Гэрэл цахилгааны төлбөрт 2015 онд 2248.1 мянган төгрөг бичигдэж 2273.1 мянган төгрөгийг төлсөн, 2016 онд 2315.5 мянган төгрөг төлөхөөс 2142.2 мянган төгрөгийг төлж, үлдэгдэл 173.4 мянган төгрөг дутуу төлөгдсөн ба тайланд өглөгөөр тусгаагүй. Сумын Эрүүл мэндийн төвийн хуучин барилгыг иргэдэд түрээслүүлсэн ба түрээслэгчдийн хэрэглэсэн цахилгааны төлбөр 2015 онд 723.4 мянган төгрөг, 2016 онд 651.6 мянган төгрөг гарсаныг төсвөөс төлсөн байна. 2015 он, 2016 оны 08 сар хүртэл түрээслэгчидтэй гэрээ байгуулаагүй байна. Харин сумын Эрүүл мэндийн төвийн дарга Д.Батжаргал нь иргэн Э.Одхүү, Ш.Энх-Амгалан нартай 2016 оны 10 сарын 01-ээс 2017 оны 05 сарын 01-нийг хүртэл, н.Нандин-Эрдэнэ, н.Хулан-Эрдэнэ

нартай 2016 оны 09 сарын 01-ээс 2017 оны 01 сарын 01-нийг хүртэл хугацаанд түрээслүүлэхээр гэрээ байгуулж, түрээсийн төлбөрт 10 сарын 01-ээс 05 сарын 01-ний өдөр хүртэл 50.0 мянган төгрөг, 05 сарын 01-ээс 10 сарын 01-ний өдөр хүртэл 30.0 мянган төгрөгөөр, иргэн Л.Цэрэндэжидтэй 2016 оны 09 сарын 01-ээс 2017 оны 01 сарын 01-нийг хүртэл хугацаанд гэрээ байгуулж, түрээсийн төлбөрт 20.0 мянган төгрөг тус тус тооцож сар бүр, хэрэглэсэн цахилгааны төлбөрийг түрээслэгчид өөрсдөө хариуцан төлөхөөр гэрээ байгуулсан байгаа ба түрээслэгдээс 2016 онд иргэн Л.Цэрэндэжид түрээсийн төлбөрт 40.0 мянган төгрөг төлж, бусад түрээслэгчид төлбөрөө төлөөгүй байна.

Нэмэлт орлогын талаар: Нэмэлт санхүүжилтийн дансаар Гамшгаас хамгаалах сангаас эрүүл мэндийн төвийн урсгал засварт 3500.0 мянган төгрөг орж ирсэн ба тус төв нь Долоон бар ХХК-иар эргэлтийн эмийн сан, сургалтын танхим, эрүүл ахуйн өрөө, чийрэгжүүлэлтийн танхимд халаалтын хэрэгсэл суурилуулахаар 2016 оны 12 сарын 10-нд гэрээ байгуулж, засварын ажлын гүйцэтгэлийг тус төвийн дарга, нягтлан бодогч, нярав нар актаар хүлээн авч, засварын үнийг Долоон бар ХХК-д 2016 оны 12 сарын 22-нд шилжүүлж өгсөн байна.

Эрүүл мэндийн газраас 2016 онд шатахууны үнэнд 192.4 мянган төгрөг ирсэн ба 1,2- р багаар улаан бурханы вакцинаар явахад зарцуулсан байна.

2015 онд амбулаторийн үзлэгээр нийт 2536 хүн үзэж 133 хүнийг хэвтэн эмчлүүлж, 670 ор хоног ашигласан ба орны эргэлт 3. Нийт 320 дуудлага ирж үүнээс алсын 97 дуудлаганд үйлчилсэн бол 2016 онд амбулаторийн үзлэгээр нийт 2723 хүн үзэж 218 хүнийг хэвтэн эмчлүүлж, 1179 ор хоног ашигласан ба орны эргэлт 4. Нийт 430 дуудлага ирж үүнээс алсын 47 дуудлаганд үйлчилсэн байна.

Сумын засаг даргын Тамгын газраас 2016 оны 01 сард мод тарьсаны урамшуулалд бэлнээр 180.0 мянган төгрөгийг хүлээн авч хүлээн авах болон үзлэгийн өрөөг хулдаасласан байна.

Цалин хөлс, нэмэгдэл цалин, урамшууллын талаар:

/мянган төгрөг/

№	Зардлын нэр	2015 он			2016 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Үндсэн цалин	161988.6	154093.8	7894.8	145919.4	146050.9	-131.6
2	Гэрээт ажлын цалин	10577.6	7219.8	3357.8			
3	Урамшилт цалин				12980.8	12647.0	333.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын дүн		172566.2	161313.5	11252.7	158900.2	158698.0	202.2
4	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ галч нарын цалин				8105.7	7622.9	482.8
5	Нийгмийн хамгааллын шимтгэл	18982.3	18195.1	787.2	17479.0	17282.7	196.3

а/. Шагнал, урамшуулал:

Дарга А.Хандашид сумын Засаг даргын 2015 оны 12 сарын 22-ны өдрийн Б/37 дугаар захирамжаар 2015 оны бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээний биелэлтээр 74 хувиар үнэлэгдсэнд үндсэн цалингийн 70% буюу 492.5 мянган төгрөг, *төвийн даргын үүрэг гүйцэтгэгч эх баригч бага эмч Г.Туулд* сумын Засаг даргын 2016 оны 04 сарын 11-ний А/36, 07 сарын 08-ны Б/16 дугаар шийдвэрээр 1, 2-р улирлын ажлын үр дүнгийн урамшууллыг үндсэн цалингийн 40%-45%- хувиар тооцож 499.8 мянган төгрөг, *дарга Д.Батжаргалд* сумын Засаг даргын 2016 оны 10 сарын 27-ны Б/26, 12 сарын 22-ны Б/34 дүгээр захирамжаар 3, 4-р улирлын ажлын үр дүнгийн урамшууллыг үндсэн цалингийн 42%-45%-иар тооцож 514.1 мянган төгрөг, сумын Засаг даргын 2016 оны 12 сарын 22-ны өдрийн Б/33 дугаар захирамжаар бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээний биелэлтээр 90 хувиар үнэлэгдсэнд үндсэн цалингийн 100%-иар буюу 655.3 мянган төгрөгийн урамшуулалт цалин тус тус олгосон байна.

Монгол улсын Засгийн газрын 150 дугаар тогтоол, Хөдөлмөрийн дотоод журмын 7.1.3 дахь заалтуудыг үндэслэж **2015 онд** сумын Эрүүл мэндийн төвийн даргын 05 сарын 25-ны өдрийн Б/06 дугаар тушаалаар 19 албан хаагчдад үндсэн цалингийн 20-40%-иар 2425.3 мянган төгрөг, 06 сарын 26-ны өдрийн Б/08 дугаар тушаалаар 19 албан хаагчдад үндсэн цалингийн 15-45%-иар 2519.1 мянган төгрөг, 10 сарын 12-ны өдрийн Б/16 дугаар тушаалаар 18 албан хаагчдад үндсэн цалингийн 5-45%-иар 2275.3 мянган төгрөг, 12 сарын 24-ний Б/21 дүгээр тушаалаар 19 албан хаагчдад үндсэн цалингийн 10-45%-иар 3425.6 мянган төгрөг нийт 10645.4 мянган төгрөг, **2016 онд** сумын Эрүүл мэндийн төвийн даргын 04 сарын 11-ний өдрийн Б/06 дугаар тушаалаар 16 албан хаагчдад үндсэн цалингийн 25-45%-иар 2923.5 мянган төгрөг, 07 сарын 07-ны өдрийн Б/17 дугаар тушаалаар 17 албан хаагчдад үндсэн цалингийн 15-40%-иар 2623.2 мянган төгрөг, 10 сарын 27-ны өдрийн Б/40 дүгээр тушаалаар 17 албан хаагчдад үндсэн цалингийн 30-44%-иар 2936.9 мянган төгрөг, 12 сарын 14-ний өдрийн 46 дугаар тушаалаар 17 албан хаагчдад үндсэн цалингийн 15-44%-иар 3050.4 мянган төгрөг нийт 11534.0 мянган төгрөг бүгд 22179.4 мянган төгрөгийн улирлын ажлын үр дүнгийн урамшуулалт цалин олгожээ.

Дүн бүртгэгч бага эмч Г.Өлзийгэрэлийг сумын Эрүүл мэндийн төвийн даргын 2016 оны 04 сарын 11-ний Б/07 дугаар тушаалаар архив албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгт 86.6 хувь дүгнэгдсэн гэж үндсэн цалингийн 70%-иар буюу 373.0 мянган төгрөг, мөн төвийн даргын 2016 оны 07 сарын 07-ны Б/21 дүгээр тушаалаар 2015 оны эрүүл мэндийн статистик тайлан мэдээний явцын үнэлгээгээр 90.8 хувьтай дүгнэгдсэн гэж 2 сарын хугацаагаар үндсэн цалингийн 30 хувиар буюу 305.2 мянган төгрөгөөр, *тогооч Н.Оюунцэцэгийг* тус төвийн даргын 2016 оны 12 сарын 23-ны Б/49 дүгээр тушаалаар аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан тогооч нарын аймгийн аварга шалгаруулах тэмцээнд амжилттай сайн оролцож “Тогоочийн алдар” одонгоор шагнагдсан гэж үндсэн цалингийн 80% буюу 364.0 мянган төгрөгөөр тус тус шагнажээ.

Сумын Эрүүл мэндийн төвийн даргын 08 сарын 30-ны Б/25 дугаар тушаалаар Эрүүл мэндийн сайдын 2012 оны 272 тоот тушаал, Эрүүл мэнд, Спортын сайдын 2016 оны “Олон улсын сувилагчийн өдөр тэмдэглэн өнгөрүүлэх тухай” А/101 дүгээр тушаал, Булган аймгийн Эрүүл мэндийн газрын салбарын төрийн албан хаагчдын “Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”, Эрүүл мэндийн газрын даргын 2016 оны 08 сарын 24-ний өдрийн А/49 тоот тушаалуудыг үндэслэж, “Олон улсын сувилагчдын баяр”-ыг тохиолдуулан “Сувилагчийн нэг өдөр” аяныг амжилттай зохион байгуулсан гэж арга зүйч-ахлах сувилагч Б.Бадамханд, сувилагч Н.Цэцэгмаа, Л.Булган, Л.Цэрэндэжид, П.Бямбасүрэн нарыг үндсэн цалингийн 10%-иар буюу 247.8 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна.

2015 онд сумын Эрүүл мэндийн төвийн даргын 12 сарын 24-ний Б/22 дугаар тушаалаар *Төсвийн тухай хуулийн 16.5.2, 16.5.5, Хөдөлмөрийн дотоод журмын 7.1.3 дахь заалтуудыг* үндэслэж үндсэн цалингийн 50%-иар эх баригч бага эмч Г.Туул, арга зүйч Б.Бадамханд, 1-р багийн бага эмч Л.Отгонтөгс, тогооч Н.Оюунцэцэг, жолооч С.Наянтай нарт, үндсэн цалингийн 100%-иар дүн бүртгэгч бага эмч Г.Өлзийгэрэл, арга зүйч П.Бямбасүрэн, сувилагч Л.Цэрэндэжид, Н.Цэцэгмаа, Л.Булган, үйлчлэгч Г.Батцэцэг, Б.Должин, Ч.Баасансүрэн, О.Хишигсүрэн, галч Т.Шуурай, Б.Баасанжаргал, С.Цогтбаатар, Н.Жигмэддорж нарт **нийт 7129.7** мянган төгрөг, **2016 онд** тус төвийн даргын 12 сарын 22-ны Б/48 дугаар тушаалаар *Төсвийн тухай хуулийн 16.5.2, 16.5.5, сумын Эрүүл мэндийн төвийн даргын тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журмын 7.1.2 (Онцгой үүрэг даалгаврыг бүтээлчээр биелүүлсэн, орон нутгийн нэрээр хаяглагдсан шинэ арга барил хэвшүүлсэн, үр дүнтэй санаачлага гарган ажилласан албан хаагчид мөнгөн шагнал олгож болно.) дахь заалтуудыг* үндэслэж, 2016 онд нүүдлийн “Гэр эмнэлэг”-ийн үйл ажиллагааг хөдөөгийн 2 багт амжилттай зохион байгуулан Японы “Жайка” төслөөс 10.0 сая төгрөгийн аппарат тоног төхөөрөмжөөр шагнагдсан гэж үндсэн цалингийн 50%-иар эчлэгч эмч Г.Ган-Оюун, 1-р багийн бага эмч Л.Отгонтөгс, 2-р багийн бага эмч С.Мягмарсүрэн, сувилагч Л.Цэрэндэжид, Н.Цэцэгмаа, Үйлчлэгч Б.Должин, Ц.Цэндээ, жолооч С.Наянтай нарт 1993.8 мянган төгрөг, 12 сарын 23-ны Б/50 дугаар тушаалаар *Төсвийн тухай хуулийн 16.5.2, 16.5.5, Хөдөлмөрийн дотоод журмын 7.1.3 (Тухайн жилийн үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргээ амжилттай биелүүлж “А”, “В” үнэлгээ авсан албан хаагчдад мөнгөн урамшуулал олгож болно.) дахь заалтуудыг* үндэслэж, хамт олноо хошуучлан ажилласан гэж үндсэн цалингийн 80%-иар дүн бүртгэгч бага эмч Г.Өлзийгэрэл, эх баригч бага эмч Б.Бадамханд, 2-р багийн бага эмч Г.Батцэцэг, сувилагч О.Хишигсүрэн, Л.Булган нарт 1881.3 мянган төгрөг нийт **3875.1 мянган төгрөгийн** урамшуулалт цалинг давхардуулж олгосон байна.

б/. Хавсран ажилласан албан тушаалын талаар:

Сумын Засаг даргын захирамжаар дарга А.Хандашид сумын эмчлэгч эмчийн албан тушаалыг хавсруулж, үндсэн цалингийн 40 хувиар тооцож 2015 онд 2170.6 мянган төгрөг, 2016 онд 548.1 мянган төгрөг, эх баригч бага эмч Г.Туулд 2015 оны 11 сард төвийн даргын үүрэг гүйцэтгэгчээр түр томилж, үндсэн цалингийн 40 хувиар тооцож, 296.9 мянган төгрөг тус тус хавсран ажилласны нэмэгдэл цалин олгосон байна.

Сумын Эрүүл мэндийн төвийн даргын тушаалаар эх баригч бага эмч **Г.Туулд** вакцинатор сувилагчийн ажлыг 2015 оны 01 сараас 2016 оны 09 сар хүртэл хавсруулж үндсэн цалингийн 30 хувиар тооцон 2015 онд 1659.6 мянган төгрөг, 2016 онд мянган төгрөг 1616.4 мянган төгрөг, **арга зүйч Б.Бадамхандад** 2016 оны 11, 12 саруудад вакцинатор сувилагчийн ажлыг хавсруулж үндсэн цалингийн 30 хувиар тооцон 281.9 мянган төгрөг, **дүн бүртгээгч бага эмч Г.Өлзийгэрэлд** архив, бичиг хэргийн ажлыг 2015 оны 8 сараас 2016 оны 12 сарыг дуустал хавсруулж үндсэн цалингийн 25 хувиар тооцон 2015 онд 615.3 мянган төгрөг, 2016 онд 1441.0 мянган төгрөг, архив бичиг хэргийн ажилтаны ахлах зэргийн нэмэгдлийг үндсэн цалингийн 10 хувиар 2015 оны 1-6 сард 319.7 мянган төгрөг, **сувилагч Л.Булганд** няравын ажлыг хавсруулж, үндсэн цалингийн 20 хувиар 2015 онд 975.5 мянган төгрөг, 2016 онд 987.1 мянган төгрөг, **Б.Энхжаргалыг** 2015 онд 04 сараас 09 сар, 2016 оны 11, 12 саруудад сувилагчаар, 10 сараас 12 сард 1-р багийн бага эмчээр ажиллуулсан ба уг хугацаанд ахлах сувилагчийн ажлыг хавсруулж үндсэн цалингийн 10-20 хувиар тооцож 2015 онд 827.3 мянган төгрөг, 2016 онд 207.4 мянган төгрөг, **сувилагч Д.Чулуунцэцэгт** ахлах сувилагчийн ажлыг 2015 оны 1-3 сард хавсруулан үндсэн цалингийн 20 хувиар тооцож 311.1 мянган төгрөг, **сувилагч Л.Цэрэндэжидэд** ахлах сувилагчийн ажлыг 2015 оны 12 сард хавсруулж, үндсэн цалингийн 20 хувиар тооцон 76.2 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгожээ.

в/. Бусад цалин, нэмэгдлийн талаар:

Ажиллагсдын үндсэн цалинг Засгийн газрын 75 дугаар тогтоолын дагуу тогтоосон байна. Албан хаагчдад 2015 онд нийт 2630.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгож бүрэн суутгасан. 2016 онд нийт 13330.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгож 12890.0 мянган төгрөгийг суутгаж, 340.0 мянган төгрөгийг тайланд авлагаар тусгаж, сувилагч Л.Булганаас 100.0 мянган төгрөгийг суутгаагүй, тайланд авлагаар тусгаагүй байна.

Эмчлэгч эмч, их эмч, бага эмч, багийн бага эмч, сувилагч, жолооч нарт Засгийн газрын 90-р тогтоолын нэмэгдэл, тогоочид 1- зэргийн, архив бичиг хэргийн ажилтанд ахлах зэргийн нэмэгдэл, эх баригч бага эмчид эх баригчийн нэмэгдэл, дуудлагад явж илүү цагаар ажилласан эмчлэгч эмч, эх баригч бага эмч, багийн бага эмч, жолооч, ээлжийн сувилагч, үйлчлэгч нарт илүү цагийн хөлс, бүх албан хаагчдад амралтын олговор олгож, ээлжийн амралтын хоногийг биеэр бүрэн эдлүүлсэн байна.

6.2 Өглөг, авлагын талаар: Авлагын хувьд 2015 оны эхэнд нийгмийн даатгалын шимтгэлийн 50.9 мянган төгрөг, “Эрүүл мэндийн довтолгоо” хөтөлбөрийн үлдэгдэл төлбөр 500.0 мянган төгрөгийн авлага дээр Залман гранд ХХК-иас түлш халаалтын 8745.2 мянган төгрөг, эргэлтийн эмийн сангаас 6.2 мянган төгрөг, нийгмийн даатгалын хэлтсээс жирэмсэн амаржсаны тэтгэмжийн 4991.8 мянган төгрөгийн авлага нэмэгдэж, нийгмийн даатгалын шимтгэлийн 5042.7 мянган төгрөгийн авлага хасагдаж, оны эцэст 9251.3 мянган төгрөгийн авлагатай байсан ба 2016 онд нийгмийн даатгалаас листын авлага 2623.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд листын авлага 2623.8 мянган төгрөг, “Эрүүл мэндийн довтолгоо” хөтөлбөрийн үлдэгдэл төлбөр 500.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулж, оны эцэст түлш халаалтын 8745.2 мянган төгрөг, эмийн 6.2 мянган төгрөгийн авлагатай байна.

Өглөгийн хувьд 2015 оны эцэст эмийн 664.9 мянган төгрөгийн өглөгтэй байсныг 2016 онд 620.1 мянган төгрөгөөр бууруулж, оны эцэст 44.8 мянган төгрөгийн эмийн өглөгтэй тайлан баланс гарсан байна.

6.3 Шилэн дансны талаар: Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны нэгдсэн системд нийт 109 мэдээлэл оруулахаас 106-г хугацаанд нь мэдээлж, 6 мэдээлэл хугацаа хоцроосон байна.

6.4. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт: 2015 оны эхний үлдэгдэл 412894.7 мянган төгрөгийн хөрөнгө дээр 37.0 мянган төгрөгөөр 2 ш ном, 300.0 мянган төгрөгөөр архив, албан хэрэг хөтлөлтийн программ худалдан авч, Байгаль орчны газраас 1672.0 мянган төгрөгийн ямаха мотоцикл үнэ төлбөргүй өгч нийт 3681.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, сумын эрүүл мэндийн төвийн даргын 2015 оны 12 сарын 30-ны А/21 тоот тушаалаар тоног төхөөрөмж 1470.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 2135.1 мянган төгрөгийн хөрөнгийг актлан данс бүртгэлээс хасч оны эцэст 412970.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2016 оны эхний үлдэгдэл 412970.7 мянган төгрөгийн хөрөнгө дээр 12.0 мянган төгрөгөөр ном /Эрүүл мэндийн чанарын менежмент/, 599.9 мянган төгрөгөөр хөлдөөгч, 870.0 мянган төгрөгөөр автоклав худалдан авч, Эрүүл мэндийн газраас зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, бичил эхо аппарат, даралт хэмжигч, тоног төхөөрөмжийн цүнх, бага оврын дэлгэц зэрэг хөрөнгийг үнэ төлбөргүй өгч, тайлант оны хагас жилийн эд хөрөнгийн тооллогоор орлогод аваагүй байсан 560.0 мянган төгрөгийн эхо аппаратыг орлогодож нийт 14985.2 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж оны эцэст 427955.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

6.5. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:

2015 оны эхний үлдэгдэл 22224.9 мянган төгрөг дээр төсвийн хөрөнгөөр 2573.6 мянган төгрөгөөр аж ахуйн, 486.0 мянган төгрөгөөр бичиг хэрэг, 2326.5 мянган төгрөгөөр 50 тн нүүрс, 7066.2 мянган төгрөгөөр шатах тослох, 3901.6 мянган төгрөгөөр хүнс, 7054.3 мянган төгрөгөөр эм боох материал худалдан авч, Эрүүл мэндийн газраас оношлогооны маркер, оношлуур 87.0 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй ирсэнийг аж ахуйн материалын тайланд орлогод авч, сумын эрүүл мэндийн төвийн даргын 2015 оны 12 сарын 30-ны А/21 тоот тушаалаар аж ахуйн материал 2346.1 мянган төгрөг актлан данс бүртгэлээс хасч 21974.2 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, оны эцэст 21399.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2015 оны 09 сард Залман гранд ХХК-тай түлээ, нүүрс нийлүүлэхээр гэрээ байгуулж, гэрээний дагуу 09 сарын 17-нд 5600.0 мянган төгрөг, 12 сарын 24-нд 5691.7 мянган төгрөг нийт 11291.7 мянган төгрөгийг Залман гранд ХХК-д шилжүүлсэнээс 2015 оны 10 сарын 10-нд 2326.5 мянган төгрөгөөр 50 тн нүүрс, 2015 оны 12 сарын 27-нд 220.0 мянган төгрөгөөр 10 м³ түлшний мод худалдан авч, үлдэгдэл 8745.2 мянган төгрөгийн түлээ нүүрсний авлагыг 2015 оны жилийн эцсийн тайланд тусгасан байна.

2016 оны эхний үлдэгдэл 21399.9 мянган төгрөг дээр 7445.0 мянган төгрөгөөр аж ахуйн, 974.0 мянган төгрөгөөр бичиг хэрэг, 9732.3 мянган төгрөгөөр түлш, шатах тослох, 5967.4 мянган төгрөгөөр хүнс, 12270.9 мянган төгрөгөөр эм боох материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 35712.2 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа

зарцуулж, оны эцэст 22077.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан баланс гарсан байна.

Санхүүгийн тайлангаар шатах тослох материалын эхний үлдэгдэл 3844.2 мянган төгрөг дээр **2015 онд** 6846.2 мянган төгрөгөөр шатахуун, 2546.5 мянган төгрөгөөр түлээ нүүрс нийт 9392.7 мянган төгрөгийн материал нэмэгдэж, 6846.3 мянган төгрөгийн шатахуун, 1558.7 мянган төгрөгийн түлээ нүүрс зарлагдаж оны эцэст 4832.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бол няравын шатах тослох материалын тайлангаар эхний үлдэгдэл 3844.2 мянган төгрөг дээр 2326.5 мянган төгрөгөөр 50 тн нүүрс авч, 5403.0 мянган төгрөгийн түлээ нүүрс, 6846.2 мянган төгрөгийн шатахуун зарцуулж оны эцэст 767.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

2016 онд санхүүгийн тайлангийн шатах тослох материалын эхний үлдэгдэл 4832.0 мянган төгрөг дээр 9732.8 мянган төгрөгөөр шатахуун авсан, зарлага нь 9732.8 мянган төгрөгийн шатахуун, 860.8 мянган төгрөгийн түлээ нүүрс зарлагдаж оны эцэст 3962.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа бол няравын шатах тослох материалын тайлангаар эхний үлдэгдэл 767.7 мянган төгрөг дээр 220.0 мянган төгрөгөөр 10 м³ мод, 9732.8 мянган төгрөгийн шатахуун орлогодож, 987.7 мянган төгрөгийн түлээ нүүрс, 9732.8 мянган төгрөгийн шатахуун зарцуулж оны эцэст үлдэгдэлгүй тайлан гаргасан байна. Сумын эрүүл мэндийн төв нь төвлөрсөн халаалтанд 2016 оны 08 сард шилжсэн байна.

ДОЛОО. ШАЛГУУЛАГЧИЙН ОЛОЛТТОЙ БОЛОН ДЭВШИЛТТЭЙ ТАЛ

1. 2015 оны 1-11 сарын касс, харилцах, хүнс, материалын баримтууд эмх цэгцтэй үдэгдэж архивлагдсан.
2. Санхүүгийн тайлан балансыг цаг хугацаанд гаргаж, зөрчилгүй тушаасан.
3. Анхан шатны баримтуудаас ээлжийн амралтын мэдэгдлийг сайн хөтөлсөн байх ба түүнд амрах болон ажилд орох огноо, нэмэгдэл амралтын хоногийг дэлгэрэнгүй тодорхой бичсэн нь амралтын олговор цалинтай давхардах эрсдлээс сэргийлсэн байна.

НАЙМ. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ

1. Сумын Эрүүл мэндийн төв нь дулаанаар хангах үйл ажиллагааг галч нараар гүйцэтгүүлсэн атал гэрээ байгуулаагүй, цалинг төрийн үйлчилгээний албан хаагчийн албан тушаалын сүлжээний цалингаар тогтоон 2016 оны 1-4 сард 7594.2 мянган төгрөгийн цалин олгосон нь Монгол улсын Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолын 4 дэх /Төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах үүрэг бүхий харуул хамгаалалт, халаалт дулаан, цэвэрлэгээ үйлчилгээг гэрээний үндсэн дээр хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх./, Сум тосгоны эрүүл мэндийн төвийн санхүүжилтийн аргачлалыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2. Монгол улсын Засгийн газрын 2012 оны 150 дугаар тогтоолыг үндэслэж тус төвийн ажиллагсдын улирлын ажлын үр дүнг улирал бүр буюу 4 удаа үнэлж дүгнэн 2015 онд 10645.4 мянган төгрөг, 2016 онд 11534.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулалт цалин олгосон атал дээр нь нэмж эрүүл мэндийн төвийн даргын тушаалаар 2015 оны 12 сард 18 албан хаагчдад үндсэн цалингийн 50-100%-иар тооцож 7129.7 мянган төгрөг, 2016 оны 12 сард 13 албан хаагчдад үндсэн цалингийн 50-80%-иар тооцож 3875.1 мянган төгрөгийн урамшуулалт цалинг давхардуулж

олгосон нь Төсвийн тухай хуулийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.5, 13.6, 13.7 дахь заалтуудыг зөрчсөн.

3. Сумын Эрүүл мэндийн төвийн даргын тушаалаар орон тоонд байхгүй дархлаажуулалтын сувилагч, архив, бичиг хэргийн ажилтан, нярав албан тушаалыг албан хаагчдад хавсруулж нэмэгдэл цалин, уламжлалтын бага эмчийн албан тушаалын орон тоо байхгүй байхад шинээр нэмж авч цалин олгосон нь Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16.5.3-д /Төсвийн шууд захирагч нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд: батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д /Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно./, 13.7-д /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно. / заасныг зөрчсөн.

4. Сумын Эрүүл мэндийн төвийн хуучин барилгыг иргэдэд түрээслүүлсэн ба түрээслэгчдийн хэрэглэсэн цахилгааны төлбөр 2015 онд 723.4 мянган төгрөг, 2016 онд 651.6 мянган төгрөг гарсаныг байгууллагын төсвөөс төлсөн, 2015 он, 2016 оны 08 сар хүртэл түрээслэгчидтэй гэрээ байгуулаагүй, 2016 оны 09 сард сумын Эрүүл мэндийн төвийн дарга Д.Батжаргал нь иргэн Э.Одхүү, Ш.Энх-Амгалан нартай 2016 оны 10 сарын 01-ээс 2017 оны 05 сарын 01-нийг хүртэл, н.Надин-Эрдэнэ, н.Хулан-Эрдэнэ нартай 2016 оны 09 сарын 01-ээс 2017 оны 01 сарын 01-нийг хүртэл хугацаанд гэрээ байгуулж, түрээсийн төлбөрт 10 сарын 01-ээс 05 сарын 01-ний өдөр хүртэл 50.0 мянган төгрөг, 05 сарын 01-ээс 10 сарын 01-ний өдөр хүртэл 30.0 мянган төгрөг, иргэн Л.Цэрэндэжидтэй 2016 оны 09 сарын 01-ээс 2017 оны 01 сарын 01-нийг хүртэл хугацаанд гэрээ байгуулж, түрээсийн төлбөрт 20.0 мянган төгрөгийг сар бүр төлүүлэхээр, хэрэглэсэн цахилгааны төлбөрөө түрээслэгчид өөрсдөө хариуцан төлөхөөр гэрээ байгуулсан ба 2016 онд иргэн Л.Цэрэндэжид түрээсийн төлбөрт 40.0 мянган төгрөг төлж, бусад түрээслэгчид төлбөрөө төлөөгүй байгаа нь Байр түрээслэх гэрээний 2.6-д /түрээслэгч нь хэрэглэсэн цахилгааны төлбөрөө өөрөө барагдуулна./, 3.1-д /10 сарын 01-ээс 05 сарын 01-ний өдөр хүртэл сарын төлбөр 50.0 мянган төгрөг, 05 сарын 01-ээс 10 сарын 01-ний өдөр хүртэл сарын төлбөр 30.0 мянган төгрөгөөр тооцоо хийнэ./, 3.3-д /гэрээгээр тодорхойлсон түрээсийн төлбөрийг сар бүрийн 30-ны өдөр тухайн сардаа багтаан түрээслэгч түрээслүүлэгчийн талд шилжүүлнэ./ заасныг хэрэгжүүлээгүй байна.

5. Нярав Л.Булган нь арилжааны банкинд байрших 5273001245 дугаар төрийн сангийн түр дансаар дамжуулан 2015 онд 1234.3 мянган төгрөг, 2016 онд 3815.1 мянган төгрөгийг бэлнээр авсан, 2015 онд бэлэн мөнгөний гүйлгээний тайлан гаргаагүй, бэлэн мөнгөний орлого, зарлагын баримт үйлдэж байгаа ч дарга, нягтлан бодогчийн гарын үсгийн бүрдэлгүй, тамга тэмдэг дарагдаагүй, сумын Засаг даргын Тамгын газраас мод тарьсаны урамшуулалд олгосон 180.0 мянган төгрөгийг бэлэн мөнгөний гүйлгээний тайланд тусгалгүй зарцуулсан.

6. 2015 оны 3-р улирлын ажлын үр дүнгийн урамшуулал, 2016 оны 12 сард тус төвийн даргын Б/48, Б/50 дугаар тушаалаар олгогдсон урамшуулалт цалингийн дэлгэрэнгүй хүснэгтийг санхүүгийн баримтанд хавсаргаагүй.

7. 2015 онд 04 сарын 29-ний 2 ш, 12 сарын 16-ны 4 ш, 12 сарын 18 –ны 6 ш, 12 сарын 24-ний өдрийн 4 ш **НИЙТ 16** , 2016 онд 02 сарын 04-ний 2 ш, 02 сарын 29-ний 3

ш, 03 сарын 25-ны өдрийн 12 ш, 04 сарын 11-ний өдрийн 1 ш, 05 сарын 10-ны өдрийн 1 ш, 11 сарын 23-ны 20 ш, 11 сарын 24-ний өдрийн 2 ш, 03 сарын 31-ний өдрийн 3 ш (даргын гарын үсэггүй) **нийт 44** төлбөрийн хүсэлтэд төрийн сангийн гүйлгээ хийсэн хүний гарын үсэг, тамга тэмдэггүй байгаа нь Засгийн газрын 2012 оны 205 дугаар тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам” –ын 8.5-д /төсвийн байгууллага төлбөрийн хүсэлт ТТ-1 маягт, бэлэн мөнгөний хүсэлт ТТ-2 маягтыг 2 хувь ямар нэгэн засваргүй бичиж ирэх бөгөөд Төрийн сан нь төлбөрийг гүйцэтгэхдээ анхан шатны болон үндэслэх баримтуудыг хяналтын хуудастай тулган хянаж, **Төрийн сангийн тэмдэг дарж, төлбөрийн хүсэлтийн нэг хувь дээр гарын үсэг зуран тэмдэг дарж баталгаажуулан төсвийн байгууллагад өгнө.** Төлбөрийн хүсэлтийн 1 хувь, хяналтын хуудсын хамт Төрийн санд үлдэнэ./ заасныг зөрчсөн.

8. Санхүүгийн тайлангийн 2016 оны жилийн эцсийн эмийн үлдэгдэл 1313.1 мянган төгрөг ахлах сувилагчийн гаргасан эмийн тайлангийн үлдэгдэл 1321.5 мянган төгрөг байгаа ба 8.4 мянган төгрөгөөр зөрсөн, эргэлтийн эмийн сан, тендерийн эмийн 2016 оны баримтуудыг үдэж архивлаагүй.

9.

№	Тайлангийн нэр	Он	Эхний үлдэгдэл	Орлого				Зарлага			Эцсийн үлдэгдэл
				Шатахуун	нүүрс	Түлшний мод	дүн	шатахуун	Түлээ, нүүрс	дүн	
1	Санхүүгийн тайлангаар	2015	3844.2	6846.3	2326.5	220.0	9392.7	6846.3	1558.7	8405.0	4831.9
2	Няравын тайлангаар		3844.2	6846.3	2326.5	0	9172.8	6846.3	5403.0	12249.3	767.7
1	Санхүүгийн тайлангаар	2016	4831.9	9732.8	0	0	9732.8	9732.8	860.8	10593.6	3971.1
2	Няравын тайлангаар		767.7	9732.8	0	220.0	9952.8	9732.8	987.7	10720.5	0

2015 онд няравын шатах тослох материалын тайлангаар оны эхний 3844.2 мянган төгрөгийн үлдэгдэл дээр 9172.8 мянган төгрөгийн материал орлогодож, 12249.3 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 767.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байхад санхүүгийн тайлангаар 8405.0 мянган төгрөгийн материалыг зарлагдаж оны эцэст 4831.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, 2016 онд няравын тайлангаар 10720.5 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст үлдэгдэлгүй тайлан гаргасан байхад санхүүгийн тайлангаар 10593.6 мянган төгрөгийн материалыг зарлагдаж оны эцэст 3971.1 мянган төгрөгийн шатах тослох материал байгаагаар тайланд тусгасан, анхан шатны баримтыг үндэслэж шатах тослох материалыг зарлагдаагүй, шилжүүлсэн мөнгөн дүнгээр зарлага болгосон байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно./ заасныг зөрчсөн.

10. Анхан шатны баримтуудыг дугаарлаагүй, хөтлөгдвөл зохих анхан шатны баримтуудаас үндсэн хөрөнгө хүлээн авах, шилжүүлэх баримт, бараа материалын тооцоо бодсон акт, бэлэн мөнгөний зарлагын баримт зэргийг хөтлөөгүй, үндсэн хөрөнгийн тайлан гаргаагүй, шатахууныг шатахуун олгох зөвшөөрлийн хуудсаар олгож байгаа ч ихэнх хуудаст зөвшөөрсөн хүний гарын үсэг зурагдаагүй, 2015 оны 08

сараас хойш жолоочийн замын хуудаст спидометрийн заалт бичигдээгүй, зөвшөөрлийн бичгээр авсан шатахууны хэмжээгээр жолоочийн замын хуудаст зарцуулсанаар түүвэрлэж бичсэн, жолоочийн шатахууны хэтрэлт, хэмнэлтийг тооцолгүй шилжүүлсэн мөнгөн дүнгээр шууд зардалд бичдэг, 2016 оны хүнс, бараа материалын тайланд гаргасан нярав, хянаж хүлээн авсан нягтлан бодогчийн гарын үсэг зурагдаагүй байгаа бол 2015 оны тайланд гарын үсэг зурагдсан ч хавсаргасан орлого, зарлагын баримтын тоо ширхэгийг тавьдаггүй, 2015 онд бэлэн мөнгөний гүйлгээний тайлан гараагүй, бараа материалыг тухай бүрд нь шаардах хуудсаар тавьж олгодоггүй авсан хэмжээгээр бөөндүүлэн зарлагаддаг, санхүүгийн баримтанд цагаан, бичигдээгүй шаардах хуудсын маягт хавсаргасан, галч нарт өдөрт 0.2 тн нүүрс, 1 м³ түлшний модыг дарга, нягтлан бодогчийн зөвшөөрсөн гарын үсэггүй байхад олгосон, Залман гранд ХХК-иас худалдан авсан гэх 50 тн нүүрс, 10 м³ түлшний модыг хэн хэн байлцаж, хэзээ буулгаж, хүлээлцсэн талаарх үйлдсэн баримт байхгүй, цалин олгох болон гарт олгох хүснэгтэд ажиллагсдын гарын үсгийн бүрдэл гүйцэт зурагдаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.6 дахь заалт, Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 тоот тушаалаар батлагдсан зааврыг зөрчсөн.

ЕС. АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж таслан зогсоох зорилгоор 1 албан шаардлага, 340.7 мянган төгрөгийг нөхөн олгох, 2516.0 мянган төгрөгийн төлбөрийг төсөвт төвлөрүүлэхээр акт тогтоолоо. Шалгалтын хугацаанд 3 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

АРАВ. ДҮГНЭЛТ

Монгол улсын Засгийн газрын 2012 оны 205 дугаар тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам” –ын 8.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.6, 13.7, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтын хэрэгжилт хангалтгүй, Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 тоот тушаалаар батлагдсан зааврыг мөрдөж ажиллаагүй, шалгалтаар илэрч байгаа нийтлэг зөрчлүүд нь байгууллага дотооддоо бүртгэлээр тавих хяналт сул байна дүгнэлээ.

АРВАН НЭГЭН. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Монгол улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2012 оны 205 дугаар тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”, Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 тоот тушаалаар батлагдсан зааврыг хэрэгжүүлж ажиллах

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

Сэлбэг шатахууны зардлын гүйцэтгэлд хяналт тавих хяналтыг сайжруулж, шатахууны тооцоог бодож хэвших, автомашины шатахууны 100 км-т зарцуулах нормыг тооцохдоо Дэд бүтцийн сайдын 2004 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 19 дүгээр тушаалаар баталсан “Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахууны

зарцуулалтын жишиг норм”, “Автомашины шатахуун зарцуулалтын нормыг тооцох заавар”-ыг мөрдөж ажиллах

Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам бичгээр ирүүлэх

Илэрсэн зөрчлүүдийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх талаар анхааран тодорхой ажил зохион байгуулж, акт, албан шаардлагын биелэлтийг албан тоотоор хүргүүлж ажиллах

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ

Ж.ОЮУН

